



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын Боловсрол сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багш, эцэг эхчүүдээс сурагчдын сургалтыг дэмжих, сурах орчныг сайжруулах зорилгоор хандивласан нийт 20,987,760.00 (хорин сая есөн зуун наян долоон мянга долоон зуун жар) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Багануур дүүргийн Боловсрол сургууль (Б.Буянхишиг)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багануур дүүргийн Боловсрол сургууль (Б.Буянхишиг)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/НОЧ дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Болосрол сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалт ад авсан он	Чанар байдал	Хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр
						нэгжийн үнэ	нийт дүн		
Машин тоног төхөөрөмж									
1	Ус шүүгч	Homelux	2025	Хятад	Ш	1	450,000.00	450,000.00	Хандив
2	Зурагт 75инч	Rotenzo	2024	Хятад	Ш	1	2,199,900.00	2,199,900.00	Хандив
3	Зурагт 70инч	Haier	2024	Хятад	Ш	2	1,599,900.00	3,199,800.00	Хандив
4	Зурагт 65инч	Haier	2024	Хятад	Ш	1	1,500,000.00	1,500,000.00	Хандив
Машин тоног төхөөрөмж						5		7,349,700.00	
Тавилга, эд хогшлын дүн									
5	Ширээ (оффис)	ДСП	2024	Хятад	Ш	12	200,480.00	2,405,760.00	Хандив
6	Багш сандал	Никель	2024	Хятад	Ш	10	60,230.00	602,300.00	Хандив
7	Ханын шүүгээ өлгүүртэй	ДСП	2024	Хятад	Ш	1	1,800,000.00	1,800,000.00	Хандив
8	Шүүгээ цагаан	ДСП	2024	Хятад	Ш	1	300,000.00	300,000.00	Хандив
9	Оффис ширээ	ДСП	2025	Хятад	Ш	25	270,000.00	6,750,000.00	Хандив
10	Оффис сандал	Дугуйтай	2025	Хятад	Ш	1	200,000.00	200,000.00	Хандив
11	Локер шүүгээ (12 нүдтэй)	Төмөр	2025	Хятад	Ш	2	480,000.00	960,000.00	Хандив
12	Тавиртай шүүгээ	ДСП	2025	Хятад	Ш	1	620,000.00	620,000.00	Хандив
Тавилга, эд хогшлын дүн						53		13,638,060	
НИЙТ ДҮН						58		20,987,760	